



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 10. 14 № 07/36 ЧАГ-САГ/2013/ЗА-01

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА С.БУЯНДАЛАЙ  
ТАНАА

Авлага барагдуулах тухай

Газрын үйлчилгээний албаны 2012 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тендерийн материалыг хуурамчаар бүрдүүлж зах зээлийн үнээс өндөр үнээр чанаргүй бараа худалдан авч улсад 19.4 сая төгрөгийн хохирол учруулсан, залилан хийж 5.6 сая төгрөгийн хөрөнгийг хувьдаа завшсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”. Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20.1.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч нь албан тушаалаа урвуулан ашиглахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийж, тендерийн материалыг хуурамчаар бүрдүүлж хууль зөрчсөн, залилан хийж хөрөнгийг хувьдаа завшсан албан тушаалтуудад хариуцлага тооцох, маргаантай авлагыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Буяндалай, Газрын үйлчилгээний албаны дарга Ч.Батхуяг нарт үүрэг болгож албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

Аудитор

Д.Гандолгор



070374